


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар буюу 6-р долоо хоногт нийт Нийслэлийн 8 дүүрэг, 9 аймагт **437** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 437 тохиолдлын 91% /397/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 9% /39/ нь орон нутагт (Баян-Өлгий /6/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /8/, Орхон /4/, Өвөрхангай /3/, Өмнөговь /3/, Төв /9/, Хөвсгөл /2/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **89** тохиолдол Баянзүрх болон Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

6 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.02.01 – 2026.02.07)

2026 оны зургаадугаар долоо хоногт 74 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, 5 жилийн дунджаас 57.5 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.

Угаарын хийн цочмог хордлогын тохиолдлын хөдлөл зүй




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 1-6 дугаар долоо хоногт нийт 189 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны зургаадугаар долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн 46 хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 48.4 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 194 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (6-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	4	9	13
2	Эмийн хордлого	13	20	33
Нийт		17	29	46

Нийт 46 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 33 (72%) нь эмийн хордлого, 13 (28%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 29 (63%) тохиолдол, санаатай хордлого 17 (37%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.